

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 5
<i>1. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудал</i>	4 – 5

---

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 10-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 48 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.*

*Томилолттой: О.Алтангэрэл, Б.Батбаатар, Ж.Батжаргал, С.Бямбацогт, Ц.Туваан;*

*Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Ж.Баярмаа, Э.Болормаа, А.Ганбаатар, Ч.Лодойсамбуу, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Л.Энх-Амгалан;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, Л.Мөнхбаатар.*

***Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудал***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 11 сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг танилцуулав.

**Ц.Сандаг-Очир:** Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг асуудлыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татзалсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

*Уг асуудлыг 11 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 03 минут үргэлжилж, 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 51 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг  
Төрийн ордны “Их засаг” танхим  
11 цаг 48 минут

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Сандаг-Очир:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн, Тогмидын Доржханд гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн, Чинбатын Номин гишүүн ирсэн, Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн ирсэн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн, Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн, Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал. Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаараар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдье. Болсон уу?

Засгийн газраас 2025 оны 11 сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнуудын хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаан 03 минут үргэлжилж, 11 цаг 51 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**